


БАТЛАВ:
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ
ДАРГА  Н.АЛТАНЦЭЦЭГ

БАЙГУУЛЛАГЫН 2024 ОНЫ 06 ДУГААР САР ХҮРТЭЛХ
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТ
ХИЙХ УДИРДАМЖ

2024.06.18

Чойр

Нэг. Удиртгал

Байгууллагын хяналт шалгалтын жилийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу санхүүгийн үйл ажиллагаанд, архив бичиг хэргийн үйл ажиллагаанд, нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтэд, авлигын эсрэг хуулийн хэрэгжилтэд, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтэд энэхүү удирдамжийн дагуу хяналт шалгалт хийнэ. Энэ чиглэлээр хяналт шалгалт хийсэн дүнг ашиглан байгууллагын удирдлага болон албан хаагчдын зүгээс нэн тэргүүнд ямар арга хэмжээ авч, цаашид юу шийдвэрлэх шаардлагатай байгааг тогтоож, зохих арга хэмжээг авах юм.

Хоёр. Хяналт шалгалтын ажлын зорилго

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын дотоод үйл ажиллагааны үр дүн, чанарыг тооцож, дотоод хяналт хийх, зөвлөн туслах, илэрсэн зөрчлийг арилгах

Гурав. Үндэслэл, хамрах хүрээ

Эрх зүйн үндэслэл: Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоол “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”

Дотоод хяналтын хамрах хүрээ: Байгууллагын 2024 оны 06 дугаар сар хүртэлх үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хүрээнд

Хамрагдах албан хаагчид: Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны албан хаагчид

Дөрөв. Дотоод хяналт шалгалтын хугацаа

Хяналт шалгалтыг 2023 оны 06 дугаар сарын 18-27-ны өдөр

Тав. Хяналт шалгалт хийх багийн бүрэлдэхүүн

Дотоод аудитор Г.Насанжаргал, Т.Отгонтамир, санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч Э.Цэлмэгбаяр

Зургаа. Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Ажлын байранд цаасан болон цахим баримтуудад тулгуурлан гүйцэтгэнэ
2. Хяналтын явц, үр дүнг нотлох баримт, фото зургаар баталгаажуулна
3. Хяналтын явцад илэрсэн зөрчлийг арилгуулах, зөвлөгөө, зөвлөмж өгөх, хугацаатай үүрэг даалгавар өгөх
4. Дотоод хяналт шалгалтын дүн, танилцуулгыг газрын даргад танилцуулж, мэдээллийг цахим хуудаст байршуулах

Долоо. Дотоод хяналт шалгалтын үр дүнг тайлагнах

Дотоод хяналт хийсэн тухай үнэлгээ, дүгнэлт, тайланг даргад 2024 оны 06 дугаар сарын 28-нд танилцуулна.

Дотоод хяналт шалгалтын дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавина.

УДИРДАМЖ БОЛОВСРУУЛСАН:

ДОТООД ХЯНАЛТЫН БАГ



Г.НАСАНЖАРГАЛ

Т.ОТГОНТАМИР

Э.ЦЭЛМЭГБАЯР